



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

ГХУНИЙ ЭМИЙН ЗӨВЛӨЛИЙН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ
ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүний эмийн зөвлөлийн мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. "Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2011 оны 402 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хүний эмийн зөвлөлийн мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.2.5-д "Эмийн фармакопейн өгүүллийн төслийн эмийн найрлага, тун, фармакологийн бүлэг болон хэрэглэх зааврыг эм судлалын шаардлагын түвшинд хянаж, санал дүгнэлт гаргах" гэсэн заалтыг нэмсүгэй.

3. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 402 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хүний эмийн зөвлөлийн мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын зарим заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй.

а/ журмын 1.2 заалтыг "Салбар зөвлөлүүдийн үндсэн зорилго нь оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх, эм, биобэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн чанартай холбоотой аливаа асуудал болон тэдгээрийн фармакопейн өгүүлэл, стандартын төсөлд эмзүй, эм судлалын чиглэлээр санал дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэхэд оршино" гэж;

б/ журмын 3.1.1 заалтыг "Эм, биобэлдмэлийн фармакопейн өгүүлэл болон биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн стандартын төслийг эмзүйн шаардлага /чанарын үзүүлэлт, шинжилгээний аргачлал, сав баглаа боодол, хаяглалт зэрэг/ болон редакцийн түвшинд хянаж, санал дүгнэлт гаргах" гэж;

в/ журмын 3.2.3 заалтыг "Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний хэрэглэх заавар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр


сурталчилах эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хянаж, баталгаажуулах” гэж;

г/ журмын 3.3.1 заалтыг “Биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндэсний үйлдвэрийн биобэлдмэл (вакцин, оношлуур, цусны бэлдмэл)-ийн хэрэглэх зааврыг хянаж, дүгнэлт гаргах” гэж;

д/ журмын 3.3.2 заалтыг “Улсын бүртгэлд бүртгүүлэх болон бусад вакцин, биобэлдмэлийн чанар, идэвх, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гаргах, вакцин, биобэлдмэлийн тандалт судалгааг хийхэд мэргэжлийн зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх” гэж;

е/ журмын 3.3.3 заалтыг “Биобэлдмэлийн фармакопейн өгүүллийн төслийг эмнэлзүйн шаардлага болон редакцийн түвшинд хянаж, мэргэжлийн зөвлөмж, санал дүгнэлт гаргах” гэж;

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 402 тоот тушаалын хоёрдугаар хавсралт болон дөрөвдүгээр хавсралтын 3.4.3 заалтыг тус тус хүчингүйд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын 2013 оны ...
тоот тушаалтын нэгдүгээр хавсралт

ХҮНИЙ ЭМИЙН ЗӨВЛӨЛИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Эмзүйн салбар зөвлөл

Дарга:

Ц.Даваасүрэн - ЭМШУИС-ийн Эмзүйн сургуулийн Эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологийн тэнхимийн эрхлэгч /зөвшилцсөнөөр/;

Нарийн бичгийн дарга:

Д.Уранчимэг – БХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн;

Гишүүд:

С.Пүрэвсүрэн - ЭМШУИС-ийн Эмзүйн сургуулийн Эмнэлзүйн эмзүйн тэнхимийн эрхлэгч /зөвшилцсөнөөр/;

Э.Сарнайзул - ЭМШУИС-ийн Эмзүйн сургуулийн Эмийн хими, ургамал судлалын тэнхимийн багш /зөвшилцсөнөөр/;

Б.Мөнхтүвшин - МХЕГ-ын Нэгдсэн төв лабораторийн эм шинжлэгч /зөвшилцсөнөөр/;

Г.Цэрэннадмид - МХЕГ-ын Нэгдсэн төв лабораторийн микробиологич /зөвшилцсөнөөр/;

Ж.Самданцоозол – Уламжлалт эм, эмийн ургамлын компаний захирал /зөвшилцсөнөөр/;

Эм судлалын салбар зөвлөл

Дарга:

П.Батхуяг - Олимпийн хорооны Сэргээшийн асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;

Нарийн бичгийн дарга:

М.Уранчимэг - БХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн;

Гишүүд:

Ш.Энхтуяа - Улсын I төв эмнэлгийн клиник эм судлаач;

Л.Цэрэндулам - Улсын III төв эмнэлгийн Эмийн сангийн эрхлэгч;

Ч.Ерөөлт - ЭМШУИС-ийн Биоанагаахын сургуулийн Эм судлалын тэнхимийн багш /зөвшилцсөнөөр/;

С.Сээсэрдорж - ЭМШУИС-ийн Уламжлалт анагаахын сургуулийн тэнхимийн эрхлэгч /зөвшилцсөнөөр/;

Э.Ганболд – Ботаникын хүрээлэнгийн Ургамлын аймаг, ангилал зүйн салбарын эрхлэгч /зөвшилцсөнөөр/;

Ч.Янжинсүрэн – Элэг судлалын клиник төвийн ерөнхий технологич /зөвшилцсөнөөр/;

Биобэлдмэл, оношлуурын салбар зөвлөл

Дарга:

Я.Амаржаргал - БХЗГ-ын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Д.Чулуунцэцэг - БХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн;

Гишүүд:

Д.Нарангэрэл - БХЗГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн;

Б.Дармаа - ЭМЯ-ны Лабораторийн ерөнхий мэргэжилтэн;

Г.Сүрэнханд - ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал;

Т.Алимаа - Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чанарын ерөнхий менежер;

Б.Мөнхтуяа - МХЕГ-ын Нэгдсэн төв лабораторийн чанарын менежер /зөвшилцсөнөөр/;

А.Дамдинсүрэн - Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбооны тэргүүн / зөвшилцсөнөөр/;

Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөл

Дарга:

Д.Мөнхбат - ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Нарийн бичгийн дарга:

Т.Мөнхтуул - БХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн;

Гишүүд:

Б.Болорчимэг - БХЗГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн;

Б.Бямбатогтох - ЭМЯ-ны Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын ерөнхий мэргэжилтэн;

Э.Эрдэнэцогт - НЭМҮТ-ийн Хоол судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан;

Д.Өлзийдулам - МХЕГ-ын Нэгдсэн төв лабораторийн менежер /зөвшилцсөнөөр/;

Г.Чойжамц - ЭМШУИС-ийн Биоанагаахын сургуулийн Эм судлалын тэнхимиийн эрхлэгч /зөвшилцсөнөөр/;

Б.Баясгалан - ЭМШУИС-ийн Эмзүйн сургуулийн Эмийн хими, ургамал судлалын тэнхимиийн эрхлэгч /зөвшилцсөнөөр/;